

АНТРЕ ГОУЛД КОМПАНИЙН ЭЗЭМШИЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛҮҮДИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Антре Гоулд Инк. (Антре) нь Монгол улс дахь өөрийн охин компани болох “Антре” ХХК-ийн нэр дээр “Оюу Толгой” ХХК-ийн 6709А тусгай зөвшөөрлийн талбайг тойрсон Шивээ Толгой (15225А) болон Жавхлант (15226А) гэсэн тусгай зөвшөөрлүүдийг эзэмшдэг болно. Антре Жавхлант болон Шивээ Толгойн тусгай зөвшөөрлийн талбайн зүүн хэсгийн талаар хамтран ажиллах хэлцэлтэй.

Монгол Улс нь “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-иар дамжуулан “Антре Гоулд” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн Оюу Толгойн хувь эзэмшлийн 34 хувийг эзэмшдэг.

Антре ХХК 2003 оноос хойш 3148Х болон 3150Х тоот хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг эзэмшиж ирсэн. 2004 оны 10 дугаар сарын 15-нд Айвенхоу Майнз Лимитед болон Антре Гоулд Инк Ашиг хуваах гэрээ (Equity Participation and Earn-In Agreement) байгуулсан бөгөөд энэхүү гэрээгээр дараахь үндсэн нөхцөлийг харилцан тохиролцсон. Үүнд:

- Айвенхоу Майнз Лимитед нь Антре Гоулд Инкийн 4.6 сая хувьцааг 4.6 сая Канад доллараар худалдаж авна.
- Айвенхоу Майнз Лимитед Антре Гоулд 3148Х, 3150Х тоот тусгай зөвшөөрлийн талбайд хийх өрөмдлөгийн ажилд 35 сая ам.доллараас илүү хөрөнгө зарцуулсан тохиолдолд:
 - Газрын гадаргуугаас доош 560 м хүртэлх гүнд орших ашигт малтмалын 70% (АГ: 30%) -ийг
 - Газрын гадаргуугаас доош 560м-с гүнд буй ашигт малтмалын 80% (АГ: 20%)–ийг тус тус эзэмшинэ.

Айвенхоу Майнз Лимитед тийнхүү 35 сая ам. доллар зарцуулсан тухайгаа 2008 оны 06 дугаар сард Антре Гоулдэд мэдэгдсэн бөгөөд Айвенхоу Майнз Лимитед, Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК (Оюу Толгой ХХК) болон Антре Гоулд–ын хооронд Эрх Шилжүүлэх Гэрээг байгуулсан.

Айвенхоу Майнз Лимитед Ашиг Хуваах гэрээний дагуу хүлээсэн эрх үүргээ Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК (Оюу Толгой ХХК)–д шилжүүлсэн бөгөөд Айвенхоу Майнз Лимитед–ийн 3148Х, 3150Х тусгай зөвшөөрлийн дагуу эзэмших 80%-ийн эзэмшил нь (гүнээс хамааран 70% байж болно) АММИ (Оюу Толгой ХХК)–д шилжсэн.

“Оюу Толгой” ХХК болон Антре–гийн хамтын ажиллагааны талбай нь Шивээ Толгой ашиглалтын тусгай зөвшөөрлийн (15225А) талбайн Зүүн хэсэг болон Жавхлант ашиглалтын тусгай зөвшөөрлийн (15226А) талбайг бүхэлд нь хамарсан.

Тусгай зөвшөөрлийн талбайн бүх нөөцийг Монгол Улсын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд албан ёсоор бүртгүүлсэн бөгөөд тэдгээр нь Хөрөнгө Оруулалтын Гэрээ болон ашигт малтмалын нөөц тогтоох төлөвлөгөөний үндэс суурь нь болдог.

Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилт Оюу Толгой ХХК нь Хөрөнгө Оруулалтын Гэрээний 15.7.8 – р зүйлд заасан нөхцлийг бүрэн биелүүлсэн бөгөөд уг заалтад:

“Антре гоулд компанийн эзэмшиж буй 3148Х, 3150Х тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талаар

АНТРЕ ГОУЛД КОМПАНИЙН ЭЗЭМШИЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛҮҮДИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (Үргэлжлэл)

Айвенхоу Майнз Лимитед компанийн өнөөгийн эдэлж буй эрхийг гэрээгээр баталгаажуулах, эсхүл холбогдох эрхийг Хөрөнгө оруулагчид шилжүүлж /ийнхүү шилжүүлсний дараа Засгийн газар уг эрхийн 34 /гучин дөрөв/ хувийг эзэмшинэ/ улмаар Засгийн газар уг хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох” гэсэн байдаг.

Энэхүү заалтыг 2005 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Антре Гоулд, Айвенхоу Майнз Лимитед болон Айвенхоу Майнз Монголиа Инк (АММИ ХХК)-ийн хооронд байгуулсан Эрх шилжүүлэх гэрээгээр хэрэгжүүлсэн. Хөрөнгө оруулалтын гэрээнд “Хөрөнгө оруулагч” гэж заасан Айвенхоу

Майнз Монголиа Инк ХХК-ийн нэрийг 2009 онд “Оюу Толгой” ХХК болгон өөрчилсөн.

2009 оны 10 дугаар сард Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний урьдчилсан нөхцөлийн дагуу 3148Х, 3150Х тоот хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг 15225А, 15226А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүд болгосон.

Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу “Эрдэнэс Оюу Толгой” ХХК нь “Оюу Толгой” ХХК-ийн 34 хувийг эзэмшдэг тул “Оюу Толгой” ХХК-ийн дээрх ашиглалтын тусгай зөвшөөрлийн 80 хувь (буюу гүнээс хамааран 70 хувийг)-ийн 34 хувийг эзэмшинэ.